



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/48/НА-СТА-ОНА

Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	хуудас:	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyo@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn
---	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Аудит, 03.15 № 64
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН "ЖИЖИГ, ДУНД
ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ
ТӨВ" НӨҮГ-ЫН ДАРГА
Х.ОТГОНЗУЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 10,416.5 сая төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, 20.1.4 заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

ЮНЕСКО-ийн "Бүтээлч хотуудын нэгдсэн сүлжээ"-нд Улаанбаатар хотыг бүртгүүлэх ажлын хүрээнд 250.0 сая төгрөгийн санхүүжилтээр 6 сарын хугацаанд 4 үе шаттай арга хэмжээг зохион байгуулж, ЮНЕСКО-д албан ёсоор бүртгэгдсэн "БАТЛАМЖ" хүлээн авсан байна.

"Цар тахлын нөлөөнд өртсөн Улаанбаатар хотын жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих" хөтөлбөр арга хэмжээний хүрээнд 2022–2023 онд 4,054.7 сая төгрөгийн 3 жилийн хугацаат зээлийг 48 аж ахуй нэгж байгууллагад олгосон байна. Зээлийн олголт, төлөлтийг Ариг, Капитрон, Голомт банкуудтай хамтран ажиллаж, гэрээний дагуу 852.2 сая төгрөг төлөгдсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилго 9 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж, үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ,
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,527,933,785.98</u>	<u>15,526,246,257.10</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	16,401,313,096.83	15,305,556,297.95
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,118,252,589.31	1,675,792,589.31
33400	Зээлийн хүүгийн авлага	61,157,882.27	57,470,889.67
335	Бусад авлага	6,322,597,127.38	6,912,814,340.33
3351	Байгууллагаас авах авлага	6,311,805,121.38	6,902,022,334.33
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,792,006.00	10,792,006.00
336	Зээлийн авлага	6,899,305,497.87	6,659,478,478.64
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	6,899,305,497.87	6,659,478,478.64
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	6,899,305,497.87	6,659,478,478.64
35	БАРАА МАТЕРИАЛ	126,620,689.15	220,689,959.15
354	Хангамжийн материал	126,620,689.15	220,689,959.15
35410	Бичиг хэргийн материал	1,726,976.15	1,486,246.15
35420	Аж ахуйн материал	12,341,882.00	12,341,882.00
35470	Бусад хангамжийн материал	112,551,831.00	206,861,831.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,307,169,736.16</u>	<u>5,041,513,032.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,307,169,736.16	5,041,513,032.38
392	Биет хөрөнгө	5,297,225,736.20	5,034,055,032.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,702,803,510.83	4,702,803,510.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-235,140,175.50	-423,252,315.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	218,616,599.00	218,616,599.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-69,149,944.19	-85,235,485.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	179,989,640.00	179,989,640.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,765,605.12	-50,381,393.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	585,858,253.08	585,858,253.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	-51,986,541.90	-94,343,775.42
393	Биет бус хөрөнгө	9,943,999.96	7,457,999.92
39301	Програм хангамж	3,770,000.00	3,770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,770,000.00	-3,770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,050,000.00	15,050,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,106,000.04	-7,592,000.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>21,835,103,522.14</u>	<u>20,567,759,289.48</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	38,983.96	00.00

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,983.96	00.00
413	Өглөг	38,983.96	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	38,983.96	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	21,835,064,538.18	20,567,759,289.48
51	Засгийн газрын хувь оролцоо	21,835,064,538.18	20,567,759,289.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	26,193,931.87	26,193,931.87
51101	Өмч: - төрийн	26,193,931.87	26,193,931.87
512	Хуримтлагдсан үр дүн	21,808,870,606.31	20,541,565,357.61
51210	Өмнөх үеийн үр дүн	12,124,455,850.19	21,808,870,606.31
51220	Тайлант үеийн үр дүн	9,684,414,756.12	-1,267,305,248.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	21,835,103,522.14	20,567,759,289.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,910,517,891.16	1,166,988,288.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,387,723,591.16	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,387,723,591.16	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,387,723,591.16	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,013,647,076.78	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49,824,344.38	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	324,252,170.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,522,794,300.00	1,166,988,288.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,500,000.00	606,090,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81,500,000.00	606,090,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,441,294,300.00	560,898,288.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,441,294,300.00	560,898,288.69
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,226,103,135.04	2,434,293,537.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,226,103,135.04	2,434,293,537.39

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	730,385,234.99	1,336,308,738.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,792,308.16	298,539,149.16
210101	Үндсэн цалин	143,014,404.16	197,767,817.16
210102	Нэмэгдэл	29,189,904.00	66,992,332.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,588,000.00	33,779,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,588,670.00	38,849,892.00
210201	Тэтгэврийн даатгал	17,654,311.00	26,819,207.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,059,190.00	3,007,671.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,566,712.00	2,406,135.00
210204	Ажилгүйдлийн даатгал	391,677.00	601,536.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,916,780.00	6,015,343.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,314,600.00	4,314,600.00
210304	Байрны түрээс	4,314,600.00	4,314,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,960,925.25	16,986,023.57
210401	Бичиг хэрэг	7,767,280.00	2,222,510.00
210402	Тээвэр, шатахуун	9,144,427.00	10,242,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,979,997.25	4,521,153.57
210404	Ном, хэвлэл	5,953,501.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	9,115,720.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	492,520.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	478,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	14,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	475,728,731.58	977,126,553.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	216,449,000.00	711,469,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	259,279,731.58	265,656,703.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	495,717,900.05	1,097,984,798.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	365,225,000.00	2,228,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	875,000.00	2,228,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	130,492,900.05	1,095,756,798.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	130,492,900.05	1,095,756,798.88

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,684,414,756.12	1,267,305,248.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,684,414,756.12	1,267,305,248.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,637,815,018.50	3,705,205,087.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,020,718.50	1,095,756,798.88
120	Нийтлэг татварын бус орлого	115,020,718.50	1,095,756,798.88
1E+05	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,020,718.50	1,095,756,798.88
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,612,875.00	1,095,756,798.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,522,794,300.00	2,609,448,288.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,500,000.00	606,090,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81,500,000.00	606,090,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,441,294,300.00	2,003,358,288.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,441,294,300.00	560,898,288.69
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	00.00	1,442,460,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,637,815,018.50	3,705,205,087.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,637,815,018.50	3,705,205,087.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,053,618.45	1,164,760,288.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,013,724.77	298,492,882.12
210101	Үндсэн цалин	138,389,751.77	210,906,782.09
210102	Нэмэгдэл	32,852,362.00	36,102,023.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,771,611.00	33,711,122.09
210104	Урамшуулал	00.00	17,772,954.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,328,269.43	38,935,143.00
210201	Тэтгэврийн даатгал	17,393,910.83	26,871,457.50

210202	Тэтгэмжийн даатгал	2,059,190.40	3,024,171.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,566,711.52	2,410,535.00
210204	Ажилгүйдлийн даатгал	391,676.88	602,636.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,916,779.80	6,026,343.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,314,600.00	4,314,600.00
210304	Байрны түрээс	4,314,600.00	4,314,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,123,424.25	16,774,143.57
210401	Бичиг хэрэг	1,999,000.00	2,010,630.00
210402	Тээвэр, шатахуун	9,144,427.00	10,242,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,979,997.25	4,521,153.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,600.00	4,080,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	478,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	163,600.00	102,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	281,110,000.00	802,163,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	281,110,000.00	802,163,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,122,761,400.05	2,540,444,798.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,992,268,500.00	1,444,688,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,991,393,500.00	1,442,460,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	875,000.00	2,228,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	130,492,900.05	1,095,756,798.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	130,492,900.05	1,095,756,798.88
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,193,931.87	00.00	12,124,455,850.20	12,150,649,782.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,193,931.87	00.00	12,124,455,850.20	12,150,649,782.07
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,684,414,756.12	9,684,414,756.12
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,193,931.87	00.00	21,808,870,606.31	21,835,064,538.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,193,931.87	00.00	21,808,870,606.31	21,835,064,538.18
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,267,305,248.70	-1,267,305,248.70
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,193,931.87	00.00	20,541,565,357.61	20,567,759,289.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,735,998,200.00	2,003,358,288.69	1,732,639,911.31	53.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,735,998,200.00	2,003,358,288.69	1,732,639,911.31	53.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,445,600.00	558,670,288.69	56,775,311.31	90.8

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,313,500.00	298,492,882.12	49,820,617.88	85.7
210101	Үндсэн цалин	224,179,200.00	210,906,782.09	13,272,417.91	94.1
210102	Нэмэгдэл	82,994,300.00	36,102,023.08	46,892,276.92	43.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,140,000.00	33,711,122.09	7,428,877.91	81.9
210104	Урамшуулал	-	17,772,954.86	(17,772,954.86)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,539,100.00	38,935,143.00	4,603,957.00	89.4
210201	Тэтгэврийн даатгал	29,606,600.00	26,871,457.50	2,735,142.50	90.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,483,100.00	3,024,171.00	458,929.00	86.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,786,500.00	2,410,535.00	375,965.00	86.5
210204	Ажилгүйдлийн даатгал	696,600.00	602,636.00	93,964.00	86.5
210205	Эрүүл мэндийн даатгал	6,966,300.00	6,026,343.50	939,956.50	86.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,314,600.00	4,314,600.00	-	100.0
210304	Байрны түрээс	4,314,600.00	4,314,600.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	18,299,400.00	16,774,143.57	1,525,256.43	91.7
210401	Бичиг хэрэг	2,013,000.00	2,010,630.00	2,370.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	11,216,400.00	10,242,360.00	974,040.00	91.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,070,000.00	4,521,153.57	548,846.43	89.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	979,000.00	580,520.00	398,480.00	59.3

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	479,000.00	478,000.00	1,000.00	99.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	102,520.00	397,480.00	20.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000,000.00	199,573,000.00	427,000.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000,000.00	199,573,000.00	427,000.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,120,552,600.00	348,931,201.12	2,771,621,398.88	11.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,120,552,600.00	348,931,201.12	2,771,621,398.88	11.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,118,252,600.00	346,703,201.12	2,771,549,398.88	11.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	2,228,000.00	72,000.00	96.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,735,998,200.00	2,003,358,288.69	1,732,639,911.31	53.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	617,745,600.00	560,898,288.69	56,847,311.31	90.8
132001	Орон нутгийн төсвөөс	617,745,600.00	560,898,288.69	56,847,311.31	90.8
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,118,252,600.00	1,442,460,000.00	1,675,792,600.00	46.3
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,118,252,600.00	1,442,460,000.00	1,675,792,600.00	46.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	17.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.0

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	606,090,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	606,090,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	606,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	602590000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	602,590,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	606090000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	606,090,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	606,090,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 10,427,396.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд: Шүүхийн шийдвэрээр төсвөөс төлсөн төлбөр 10,892.0 мянган төгрөгийг барагдаагүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 55 нэр төрлийн 89 ширхэг хөрөнгийг (63,669.0 мянган төгрөг) дахин үнэлж бүртгээгүй байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгаагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" заалт, 19.2-т "Шалгаагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-2: 2014 - 2015 онд Капитал банкаар дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон, хугацаа хэтэрсэн 3,711,567.8 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү, алданги тооцсон авлагын үлдэгдэл барагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгаагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2-т "Шалгаагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-3: Хадгаламж зээлийн хоршоодод 2014 - 2016 онд олгосон, шүүхийн шийдвэртэй хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 6,704,936.7 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" заалт хэрэгжээгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс:				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн

